

**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ  
ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,  
БҮГД НАЙРАМДАХ ХОРВАТ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хорват Улсын Засгийн газар, цаашид "Хэлэлцэн тохиролцогч талууд" гэх,

Хоёр улсын хоорондын найрсаг харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэн,

Хэлэлцэн тохиролцогч талуудын дипломат болон албан паспорт эзэмшигч иргэдийг хоёр улсын хооронд харилцан зорчихыг хөхиүлэн дэмжиж, уг нөхцөлийг хөнгөвчлөхийг зорьж,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

**1 дүгээр зүйл**

1. Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэн орсноос хойш гуч (30)-аас дээшгүй хоног визгүйгээр нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөх болон зорчих эрхтэй.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт гуч (30)-ээс дээш хоногийн хугацаанд зорчих тохиолдолд урьдчилан виз авах үүрэгтэй.

**2 дугаар зүйл**

Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байгаа Дипломат төлөөлөгчийн газар, Консулын төлөөлөгчийн газар болон Олон улсын

байгууллагад ажиллахаар томилогдсон Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд болон тэдгээрийн хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсад ирэхээсээ өмнө зөвшөөрлийн (аккредитаци) виз авах үүрэгтэй.

### **3 дугаар зүйл**

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор "Хүчин төгөлдөр паспорт" гэдэгт Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын нутаг дэвсгэрээс гарах үед доод тал нь гурван (3) сарын хүчинтэй хугацаатай паспортыг ойлгоно.

### **4 дүгээр зүйл**

Энэхүү хэлэлцээрийн 1 болон 2 дугаар зүйлд заасан Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын олон улсын зорчигчдод нээлттэй хилийн боомтоор нэвтрэн орох, дамжин орох, эсхүл гарах бөгөөд тухайн Хэлэлцэн тохиролцогч талын шилжилт хөдөлгөөний тухай хууль тогтоомжийн дагуу бүх шаардлагатай журмыг мөрдөнө.

### **5 дугаар зүйл**

Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа тухайн улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүргээс чөлөөлөгдөхгүй.

### **6 дугаар зүйл**

Энэхүү хэлэлцээр нь тааламжгүй гэж үзсэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын аливаа иргэнийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрэх, эсхүл зорчих хугацааг багасгах, эсхүл цуцлах Хэлэлцэн тохиролцогч талын эрхийг хөндөхгүй.

### **7 дугаар зүйл**

Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зогсоох эрхтэй. Ийм арга хэмжээ авах болон эргүүлэн цуцлах тухайгаа

Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа дипломат шугамаар урьдчилан мэдэгдэнэ.

#### **8 дугаар зүйл**

1. Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор дипломат болон албан паспортын загварыг дипломат шугамаар солилцоно.

2. Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал шинэ дипломат болон албан паспорт нэвтрүүлэх, эсхүл өөрийн ашиглаж буй дипломат болон албан паспортод өөрчлөлт оруулах тохиолдолд тэрхүү шинэ, эсхүл өөрчлөлт оруулсан дипломат болон албан паспортын загварыг тэдгээрийг ашиглах зааварчилгааны талаарх мэдээллийн хамт шинэ паспорт нэвтрүүлэх болон паспортод өөрчлөлт оруулахаас доод тал нь гуч (30) хоногийн өмнө эдгээр паспортын загварыг дипломат шугамаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа хүргүүлнэ.

#### **9 дүгээр зүйл**

Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх, эсхүл тайлбарлахтай холбогдуулан үүссэн аливаа маргааныг дипломат шугамаар зөвшилцөх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

#### **10 дугаар зүйл**

Хэлэлцэн тохиролцогч талууд бичгээр харилцан тохиролцож энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Аливаа тийм нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийн нэг хэсэг болох бөгөөд энэхүү хэлэлцээрийн 11 дүгээр зүйлд дурдсан журмын дагуу хүчин төгөлдөр болно.

#### **11 дүгээр зүйл**


1. Энэхүү хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулав.

2. Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгох талаар дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн бичгэн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.


3. Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал дипломат шугамаар хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа бичгэн мэдэгдэл хүргүүлэх замаар энэхүү хэлэлцээрийг цуцалж болно. Ийм тохиолдолд энэхүү хэлэлцээр уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ер (90) хоногийн дараа хүчингүй болно.


Улаанбаатар хотноо 2016 оны 7 дугаар сарын 15-ны өдөр монгол, хорват, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ ХОРВАТ  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ





**SPORAZUM  
IZMEĐU  
VLADE MONGOLIJE  
I  
VLADE REPUBLIKE HRVATSKE  
O UKIDANJU VIZA  
ZA NOSITELJE DIPLOMATSKIH I SLUŽBENIH PUTOVNICA**

Vlada Mongolije i Vlada Republike Hrvatske, u daljnjem tekstu „ugovorne stranke“,

vođene željom da razvijaju daljnje prijateljske odnose između dviju država,

u želji da promiču, olakšaju i potaknu razmjenu posjeta dužnosnika ugovornih stranaka ukidanjem viza za nositelje njihovih diplomatskih i službenih putovnica,

sporazumjele su se kako slijedi:

**Članak 1.**

1. Državljeni bilo koje ugovorne stranke koji imaju valjane diplomatske i službene putovnice oslobođeni su zahtijevanja vize za ulazak, boravak na, izlazak iz ili prolazak kroz državno područje druge ugovorne stranke u razdoblju koje nije dulje od trideset (30) dana od datuma njihova ulaska.

2. Državljeni bilo koje ugovorne stranke iz stavka 1. ovoga članka, koji žele boraviti više od trideset (30) dana na državnom području druge ugovorne stranke, trebaju unaprijed pribaviti vizu.

**Članak 2.**

Državljeni bilo koje ugovorne stranke koji imaju valjane diplomatske i službene putovnice, koji su upućeni u diplomatske misije, konzularne urede ili su predstavnici u međunarodnim organizacijama smještenima na državnom području druge ugovorne stranke, kao i članovi njihovih obitelji koji imaju

valjane diplomatske i službene putovnice, trebaju pribaviti vizu za akreditaciju u državi primateljici prije njihova dolaska.

### **Članak 3.**

Za potrebe ovoga Sporazuma, „valjana putovnica“ znači putovnicu koja, u trenutku izlaska iz državnoga područja jedne ugovorne stranke, vrijedi još najmanje tri (3) mjeseca.

### **Članak 4.**

Državljeni bilo koje ugovorne stranke iz članaka 1. i 2. ovoga Sporazuma ulaze i izlaze iz državnoga područja druge ugovorne stranke na, ili prolaze kroz svaki granični prijelaz otvoren za međunarodni putnički promet pod uvjetom da ispunjavaju potrebne formalnosti u skladu s useljeničkim zakonima i propisima te ugovorne stranke.

### **Članak 5.**

Ovaj Sporazum ne oslobađa državljane bilo koje ugovorne stranke koji imaju valjane diplomatske i službene putovnice od obveze da poštuju zakone i propise koji su na snazi na državnom području druge ugovorne stranke tijekom njihova boravka u toj ugovornoj stranci.

### **Članak 6.**

Ovaj Sporazum ne ograničava pravo bilo koje ugovorne stranke da odbije ulazak ili skрати ili ukine boravak na svom državnom području svakom državljaninu druge ugovorne stranke kojeg smatra nepoželjnim.

### **Članak 7.**

Svaka ugovorna stranka može obustaviti primjenu ovoga Sporazuma, u cijelosti ili djelomice, iz razloga nacionalne sigurnosti, javnoga poretka ili javnoga zdravlja. O uvođenju kao i o ukidanju takve mjere, druga ugovorna stranka obavješćuje se bez odgode unaprijed diplomatskim putem.

### **Članak 8.**

1. Ugovorne stranke će razmijeniti, diplomatskim putem, uzorke svojih diplomatskih i službenih putovnica najkasnije trideset (30) dana od datuma potpisivanja ovoga Sporazuma.

2. U slučaju uvođenja novih diplomatskih i službenih putovnica ili izmjene takvih postojećih putovnica, ugovorne stranke će dostaviti jedna drugoj, diplomatskim putem, uzorke tih putovnica uz detaljne obavijesti o njihovoj primjenjivosti najmanje trideset (30) dana prije njihova uvođenja ili izmjene.

#### Članak 9.

Svaki spor koji proizlazi iz tumačenja ili primjene ovoga Sporazuma rješavat će se prijateljski konzultacijama između ugovornih stranaka diplomatskim putem.

#### Članak 10.

Ovaj se Sporazum može izmijeniti i dopuniti u pisanom obliku uzajamnim pristankom ugovornih stranaka. Svaka takva izmjena i dopuna, koja čini sastavni dio ovoga Sporazuma, stupa na snagu u skladu s postupkom predviđenim u članku 11. ovoga Sporazuma.

#### Članak 11.


1. Ovaj se Sporazum sklapa na neodređeno vrijeme.

2. Ovaj Sporazum stupa na snagu trideset (30) dana od datuma primitka posljednje pisane obavijesti kojom ugovorne stranke obavješćuju jedna drugu, diplomatskim putem, o okončanju njihovih unutarnjih pravnih postupaka potrebnih za stupanje na snagu ovoga Sporazuma.

3. Svaka ugovorna stranka može okončati ovaj Sporazum dostavom pisane obavijesti drugoj ugovornoj stranci diplomatskim putem. U tom slučaju, ovaj Sporazum prestaje biti na snazi devedeset (90) dana od datuma primitka takve obavijesti.

Sastavljeno u Ulaanbaatar dana .....u dva izvornika, svaki na mongolskom, hrvatskom i engleskom jeziku, pri čemu su svi tekstovi jednako vjerodostojni. U slučaju razlika u tumačenju, mjerodavan je engleski tekst.

ZA VLADU  
MONGOLIJE



ZA VLADU  
REPUBLIKE HRVATSKE

